**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 18 өдөр Дугаар А/66 Рашаант сум

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ногоон бүсэд хамаарах Сандил 60, 61 хэсэглэл, Тээл, Талын ус багуудын нутагт орших Дулаан хан уулын 54, 55, 56, 57, 67, 68, 69, 70, 71 хэсэглэлүүдийн ойн талбайд якобсоны төөлүүрч эрвээхэйн тархалт илэрч, хортон шавж устгах тэмцлийн ажлыг 2024 оны 06 сарын 18-ны өдрөөс 2024 оны 06 сарын 28-ны хооронд зохион байгуулж байгаа тул энэ хугацаанд голомт бүхий газарт хүн, мал тэжээвэр амьтан нэвтрүүлэхгүй хорио цээр тогтоосугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж, хорио цээр тогтоосон хугацаанд нийт иргэдэд мэдээлж, хяналт тавьж ажиллахыг Цэнгэл, Талын ус багийн Засаг дарга (Б.Баянбаатар, С.Далай, Б.Мөнхнасан) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.АЛТАНГЭРЭЛ

D:\nasaa bichig hereg\A-Zax.doc

6706011?0